



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хорооны 2008 оны 05, 186 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааварт зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7.1, 7.2 дахь заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ “7.1. “ББСБ-ын хоёрдогч өглөг гэж” гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх өрийн бичгийг хэлнэ.


2/ 7.2. ББСБ-ын хоёрдогч өглөгийн үндсэн өрийг ББСБ-ыг татан буулгасан, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулсан, Хорооноос урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахыг хориглоно.”

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар”-ын “Г-5 Хоёрдогч өглөгийн бүртгэл” хэсгийн “Захиран зарцуулах эрхийг хязгаарласан, 5 жилээс дээш хугацаатай, үйл ажиллагааны эцсийн үр дүнд дүрмийн санд оруулах болзолтой эх үүсвэрийг ББСБ-ын өөрийн хөрөнгөд оруулж балансанд Хоёрдогч өглөгийн дансанд бүртгэнэ.” гэснийг “Тэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувь нийлүүлэгчдын хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих болзолтой эх үүсвэрийг ББСБ-ын өөрийн хөрөнгөд оруулж балансанд Хоёрдогч өглөгийн дансанд бүртгэнэ.” гэж өөрчлөн найруулсугай.

039049

3. Журам, зааварт нэмэлт, өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасгай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН